



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/283

Чингис хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэл, Үнэлгээний хорооны 02 дугаартай зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд зарласан “Бог мал угаалгын ванн шинээр барих” тендерт “Смартлифт” ХХК-ний тендерийн баримт бичиг хамгийн сайн үнэлэгдсэн дүгнэлтийг Үнэлгээний хорооноос ирүүлсэн тул тус аж ахуй нэгжид гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Тендерт шалгарсан “Смартлифт” ХХК-тай Бог малын угаалгын ванн шинээр барих гэрээг тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан байгуулж ажиллахыг аймгийн Мал эмнэлэгийн газар (Ж.Энх-Амгалан), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө сруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010513